

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААДА ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД



ГАДААДАД 6, ТҮҮНЭЭС ДЭЭШ САРЫН ХУГАЦААГААР ОРШИН СУУГАА АЙМГИЙН ХАРЬАТ ИРГЭДИЙН ТОО

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр хүн амын гадаад улс орнууд руу хийх шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн. “Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй” гэсэн Үндсэн хуулийн заалт нь иргэдийг гадаад зорчих, сурах, ажиллах, эх орондоо дуртай цагтаа эргэн ирэх эрх зүйн үндэс болдог.

Монгол Улсын “Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай” хуульд гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж, ажиллаж амьдарч, сурч байгаа иргэдийнхээ талаар бодитой тоо мэдээллийг тодорхойлох асуудлыг хуульчилсан байдаг.

Сурч боловсрох, хөдөлмөр эрхэлж, амьжиргаагаа дээшлүүлэх, бизнес эрхлэх, эрүүл мэндийн үйлчилгээ авах, гэр бүл болох зэрэг олон шалтгааны улмаас манай улсын иргэд гадаадын улс орнуудад зорчих хөдөлгөөн улам бүр нэмэгдэж байна. Энэ талаарх бүртгэл, албан ёсны тоо мэдээлэл өнөө хэр байхгүй байсныг шийдвэрлэх үүднээс Гадаад харилцааны яам, Үндэсний Статистикийн Хороо хамтран гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийг бүртгэх маягтыг боловсруулж, маягтын дагуу www.citizen.gov.mn гэсэн цахим систем хөгжүүлэн 2018 оны 3-р улирлаас эхлэн нэвтрүүлсэн. Гэвч иргэдэд мэдээлэл хүргэх, бүртгэлийг идэвхжүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг тогтмолжуулах зэрэг нөхцөл байдлаас үүдэн энэ удаагийн гадаадад суугаа Монгол Улсын иргэдийн тооллогын дүнг Хил, хамгаалах ерөнхий газар (ХХЕГ), Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ)-ын мэдээллийн сангууд болон хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээллийн санг уялдуулах, өрхөөс асуусан тооллогын асуулгын мэдээллийг нэгтгэн гаргалаа. Тооллогын мэдээлэл цуглуулалт Монголд байх гэр бүлээс асуух, нөгөө талаас гадаадад оршин суугаа иргэд өөрсдөө интернэтээр (www.citizen.gov.mn) тоолуулахаар зохион байгуулсан юм.

ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТОО, НАС, ХҮЙСИЙН БҮТЭЦ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын дүнгээр гадаадад оршин суугаа 429 иргэн тоологдож 2010 оноос 54.9 хувиар өсчээ. Гадаадад оршин суугаа иргэдийн насны бүтцийг харвал 0-14 насны хүн ам 10.3 хувь, 15-44 насныхан 82.9 хувь, 45 түүнээс дээш насны хүн ам 6.8 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, гадаадад удаан хугацаагаар суугаа хүн амын 10 хүн тутмын 9 нь хөдөлмөрийн насны хүн ам байна (Хүснэгт 11.1).


ХҮСНЭГТ 11.1.ГАДААДАД ОРШИН СУУГАА ДУНДГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ ХҮЙСЭЭР, 2010, 2020 ОН

Насны бүлэг	2010			2020			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	277	149	128	429	206	223	92.4

0-4	11	6	5	14	8	6	133.3
5-9	6	4	2	16	8	8	100.0
10-14	7	5	2	14	7	7	100.0
15-19	17	10	7	22	12	10	120.0
20-24	66	41	25	96	47	49	95.9
25-29	80	44	36	83	46	37	124.3
30-34	45	23	22	80	33	47	70.2
35-39	29	11	18	49	24	25	96.0
40-44	10	4	6	26	11	15	73.3
45-49	4	1	3	19	6	13	46.2
50-54	1	-	1	4	1	3	33.3
55-59	1	-	1	4	2	2	100.0
60-64	-	-	-	1	-	1	-
70+	-	-	-	1	1	-	-


Гадаадад оршин суугаа Дундговь аймгийн иргэдийн нас, хүйсийн бүтцийг суваргаар харвал ихэнх хувийг хөдөлмөр эрхлэх насныхан эзэлж байгаа нь харагдаж байна (Зураг 11.1). Мөн 2010 оны насны бүтэцтэй харьцуулахад 0-14 насны хүүхдүүдийн тоо 83.3 хувиар нэмэгдсэн байгаа нь гэр бүлээрээ гадаадад удаан хугацаагаар суралцах болон хувиараа хөдөлмөрлөх шалтгаанаар оршин суух болсонтой холбоотой харагдаж байна.

ЗУРАГ 11.1. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН НАС ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2020 ОН



Зуун эмэгтэйд ногдох эрэгтэй хүн ам буюу хүйсийн харьцаа 92.4 байгаа (48 хувь эрэгтэй, 52.0 хувь эмэгтэйчүүд) нь гадаадад оршин суугаа эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс олон байгааг илтгэх бөгөөд 2010 онтой харьцуулахад уг үзүүлэлт 23.9 пунктээр буурсан байна . Хүйсийн харьцаа ерөнхийдөө насны бүлэг ахих тутам буурч байна. 15-19, 25-29 насанд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс олон байгаа бол 20-24, 30-54 насанд дийлэнх нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, 2010, 2020 ОН



ХҮСНЭГТ 11.2. ГАДААДАД ОРШИН СУУГАА АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН СУМДААР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин сууж байсан сум	Тоо	Бүгд	Оршин суугаа хугацаа			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
Сайнцагаан	199	100.0	42.7	35.7	13.6	8.0
Адаацаг	12	100.0	50.0	41.7	-	8.3
Баянжаргалан	8	100.0	50.0	37.5	-	12.5
Говь-Угтаал	13	100.0	23.1	38.5	30.8	7.7
Гурвансайхан	20	100.0	30.0	50.0	5.0	15.0
Дэлгэрхангай	16	100.0	37.5	25.0	12.5	25.0
Дэлгэрцогт	13	100.0	46.2	7.7	7.7	38.5
Дэрэн	20	100.0	40.0	30.0	10.0	20.0
Луус	7	100.0	14.3	42.9	14.3	28.6
Өлзийт	22	100.0	36.4	36.4	13.6	13.6
Өндөршил	9	100.0	44.4	44.4	11.1	-
Сайхан-Овоо	17	100.0	17.6	47.1	35.3	-
Хулд	16	100.0	25.0	68.8	6.3	-
Цагаандэлгэр	17	100.0	41.2	35.3	5.9	17.6
Эрдэнэдалай	40	100.0	37.5	45.0	7.5	10.0

Гадаадад тоологдсон иргэдийн 158 хүн (36.8%) Өмнөд солонгос, 51 хүн (11.9%) Япон, 42 хүн (9.8%) Чех, 35 хүн (8.2%) Швед, 28 хүн (6.5%) Хятад, 20 хүн (4.7%) Австрали, 18 хүн (4.2%) Америк, 16 хүн (3.7%) Турк улсад үлдсэн 61 хүн (14.1%) нь бусад улсад суугаагаар тоологдсон байна.

Монголчууд гадаадад чөлөөтэй зорчих болсноос хойш 30 гаруй жил өнгөрчээ. Иргэдийн гадаадад оршин суугаа хугацааг авч үзэхэд 38.7 хувь нь 1 жил хүртэлх буюу дийлэнх, 38.0 хувь нь 2-5 жил, 12.4 хувь нь 6, түүнээс дээш жил, үлдсэн 11.0 хувь нь 11, түүнээс дээш жил гадаадад амьдарч байна

ХҮСНЭГТ 11.3. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭДИЙН ТОО, ОРШИН СУУГАА УЛС, ОРШИН СУУГАА ХУГАЦАА, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Оршин суугаа улс	Тоо	Бүгд	Оршин суугаа хугацаа			
			0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш жил
Бүгд	429	100.0	38.7	38.0	12.4	11.0
Солонгос /Өмнөд/	158	100.0	43.7	41.1	8.2	7.0
Америк	18	100.0	22.2	27.8	16.7	33.3
Япон	51	100.0	41.2	49.0	5.9	3.9
Чех	42	100.0	28.6	26.2	9.5	35.7
Австрали	20	100.0	25.0	60.0	15.0	-
Хятад	28	100.0	71.4	14.3	14.3	-

Герман	9	100.0	33.3	44.4	22.2	-
Швед	35	100.0	20.0	20.0	37.1	22.9
Франц	3	100.0	66.7	-	-	33.3
Орос	6	100.0	16.7	66.7	-	16.7
Турк	16	100.0	43.8	37.5	18.8	-
Австри	2	100.0	-	50.0	50.0	-
Швейцар	4	100.0	50.0	25.0	25.0	-
Их Британи	2	100.0	50.0	50.0	-	-
Унгар	8	100.0	25.0	62.5	12.5	-
Энэтхэг	9	100.0	44.4	55.6	-	-
Польш	2	100.0	50.0	-	-	50.0
Ирланд	2	100.0	50.0	-	-	50.0
Бусад	14	100.0	28.6	50.0	14.3	7.1

Энэ удаагийн тооллогоор нийт өрхийн 10 хувиас уламжлалт асуулгаар мэдээлэл цуглуулахдаа гадаадад оршин суугаа иргэдээс анх явсан зорилго болон тооллогын үед сууж байгаа зорилгыг тодруулсан. Уг дүнгээр гадаадад оршин суугаа нийт иргэдийн дийлэнх нь буюу 39.6 хувь нь анх суралцахаар гадаад улс руу явсан байна. (Хүснэгт 11.4).

ХҮСНЭГТ 11.4. ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ОРШИН СУУГАА УЛС, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН


Оршин суугаа улс	Хүний тоо	Дүнд эзлэх хувь	Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллах	Албан томилолтоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух	Бусад
БҮГД	429	100.0	39.6	0.9	17.5	0.9	29.4	9.8	1.9
Солонгос /Өмнөд/	158	100.0	25.3	1.3	28.5	1.3	34.2	7.6	1.9
Америк	18	100.0	55.6	5.6	5.6	-	27.8	5.6	-
Япон	51	100.0	78.4	-	2.0	2.0	15.7	2.0	0.0
Чех	42	100.0	14.3	2.4	21.4	-	45.2	14.3	2.4
Австрали	20	100.0	70.0	-	-	-	20.0	5.0	5.0
Хятад	28	100.0	64.3	-	3.6	-	14.3	14.3	3.6
Герман	9	100.0	66.7	-	11.1	-	11.1	11.1	-
Швед	35	100.0	28.6	-	17.1	-	31.4	22.9	-
Франц	3	100.0	66.7	-	-	-	-	-	33.3
Орос	6	100.0	83.3	-	-	-	16.7	-	-
Турк	16	100.0	-	-	37.5	-	43.8	12.5	6.3
Австри	2	100.0	50.0	-	-	-	50.0	-	-
Швейцар	4	100.0	50.0	-	-	-	50.0	-	-
Их Британи	2	100.0	100.0	-	-	-	-	-	-

Унгар	8	100.0	-	-	-	-	37.5	62.5	-
Энэтхэг	9	100.0	100.0	-	-	-	-	-	-
Польш	2	100.0	-	-	-	-	100.0	-	-
Ирланд	2	100.0	-	-	-	-	-	-	-
Бусад	14	100.0	35.7	-	28.6	7.1	21.4	7.1	-

Энэ удаагийн тооллогын дүнгээр нийт иргэдийн 39.6 хувь нь сурах, 47.8 хувь нь хөдөлмөр эрхлэх (үүнээс 29.4 хувь нь хувиараа, 17.5 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр, 0.9 хувь нь албан томилолтоор ажиллах), 9.8 хувь нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух, 0.9 хувь нь суурьших, үлдсэн 1.9 хувь нь бусад зорилгоор эх орноосоо явжээ. (Хүснэгт 11.4).

Явсан зорилгыг оршин суугаа улсаар авч үзвэл Солонгос /Өмнөд/, Япон, БНХАУ, Австрали руу хамгийн олон хүн суралцахаар (нийт сурахаар явагчдын 65.9 хувь), БНСУ, Чехруу хамгийн их хүн хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар (нийт хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явагчдын 72 хувь), БНСУ, Чехруу руу хамгийн их хүн хувиараа хөдөлмөрлөхөөр (нийт хувиараа хөдөлмөрлөхөөр явагчдын 57.9 хувь) явсан байна (Хүснэгт 11.4).

ЗУРАГ 11.3 ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН






Тооллогын үед гадаадад байнга суугаа зорилгыг 2010 оны тооллогын дүнтэй харьцуулбал хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хувь 10.3 пунктээр буурч, суралцах зорилгоор суугаа иргэдийн хувь 3.9 пунктээр, хувиараа ажиллах зорилгоор ажиллаж буй иргэдийн хувь 7.4 пунктээр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 11.5.ГАДААДАД ОРШИН СУУГАА ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА
 ЗОРИЛГО, НАСНЫ БҮЛЭГ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН

Насны бүлэг	Бүгд	Тооллогын үед сууж байгаа зорилго							Бусад
		Суралцах	Суурьших	Хөдөлмөрийн н гэрээгээр ажиллах	Албан томиллолтоор ажиллах	Хувиараа ажиллах	Гэр бүлийн шалтгаанаар оршин суух		
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
0-4	3.3	1.2	25.0	-	-	0.8	21.4	12.5	
5-9	3.7	4.7	-	-	-	-	19.0	-	
10-14	3.3	3.6	25.0	-	-	-	14.3	12.5	
15-19	5.1	11.8	-	-	-	-	4.8	-	
20-24	22.4	44.4	-	10.7	-	9.4	0.0	12.5	
25-29	19.3	19.5	-	28.0	50.0	18.9	4.8	12.5	
30-34	18.6	11.8	50.0	22.7	-	26.8	11.9	25.0	
35-39	11.4	2.4	-	20.0	50.0	18.9	7.1	12.5	
40-44	6.1	0.6	-	5.3	-	14.2	4.8	12.5	
45-49	4.4	-	-	8.0	-	10.2	-	-	
50-54	0.9	-	-	2.7	-	-	4.8	-	
55-59	0.9	-	-	2.7	-	-	4.8	-	

Гадаадад оршин суугаа иргэдийн тооллогын үед сууж байгаа зорилгыг насны бүлгийн хувьд харвал суралцах зорилгоор оршин суугаа хүмүүсийн 87.5 хувь нь 15-34 насныхан байна. Хувиараа хөдөлмөрлөх зорилгоор суугаа хүмүүсийн 78.8 хувийг 25-44 насныхан эзэлж байна.

ЗУРАГ 11. 2.ГАДААДАД ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД, НАСНЫ БҮЛЭГ, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН



АРВАН ХОЁРДУГАР БҮЛЭГ

ӨРХИЙН ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, АХУЙН НӨХЦӨЛ



СУУЦНЫ ТӨРӨЛ

Хүний амьдралын анхдагч хэрэгцээ, эрүүл энх, тав тухтай, аюулгүй амьдрах үндсэн орчин бол орон сууц юм. Төр, засгийн бодлогын нэг хэсэг нь хүн амаа орон сууцаар хангаж, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэдэг.

Монгол Улс хүн ам, орон сууцны тооллогоор орон сууц, тэдгээрийн дэд бүтцийн хангамжийн байдлыг нэлээд өөр өөр аргачлалаар тоолж ирсэн. Улс, хоршооллын байгууллагын орон сууцны сан хөмрөгийн тооллогыг 1969 онд анх удаа зохион байгуулж байжээ. Харин хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогуудад орон сууцны сан хөмрөгийн тооллого явуулаагүй, хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, өмчлөл болон эзэмшлийн хэлбэр, дэд бүтцийн хангамжийг хүн амын тооллоготой хамтатган явуулж байсан.

Энэ удаа хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор хүн амын амьдарч буй орон сууцны төрөл, түүний нөхцөлийн талаарх үзүүлэлтүүдийг цуглуулахаас гадна хүн амьдран суух зориулалттай бүх төрлийн орон сууц, түүний насжилт, хана болон дээврийн материал, дэд бүтцийн талаарх мэдээллийг цуглуулах зорилготой Байшин, орон сууцны тооллогыг 2019 онд улс орон даяар зохион байгуулж явуулсан. Байшин орон сууцны тооллого 2019 онд явагдсан тул мэдээллийн хугацааг 2019 оноор авсан. Зуслангийн суурьшлын бүс харгалзахгүйгээр улирлын чанартай амьдардаг байшин, орон сууцыг урьдчилсан бүртгэлээр бүртгэж, харин хүн амьдран суух зориулалттай үндсэн сууцны мэдээллийг тооллогоор цуглуулсан ба дараах орон сууцыг хамруулсан. Үүнд:

1. Бүх төрлийн гэр
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн зориулалттай орон сууцны байшин
5. Нийтийн байр

Мөн Байшин, орон сууцны тооллогод хамрагдсан бүх орон сууцнаас хүн байнга амьдардаг эсэхийг тодруулж, хүн байнга амьдардаг орон сууцны насжилт, хана, шал, дээврийн материал, дэд бүтэц зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж тоолсон.

Харин хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор тоологдсон өрхийн амьдарч буй сууцны нөхцөлийн мэдээллийг хүн ам, өрхийн мэдээллийн сан болон уламжлалт тооллогоор өрхийн орон сууцны нөхцөлийн талаарх мэдээллийг цуглуулсан. Ингэхдээ эхлээд өрх ямар төрлийн сууцанд амьдарч байгааг асууж, дараа нь сууцны ахуйн нөхцөлийн үзүүлэлтүүдийг тодорхойлсон. Тоолох үед өрхийн амьдарч буй сууцыг ерөнхийдөө хүн амьдрах зориулалтаар нь гэр, байшин, бусад сууц /зориулалтын бус/ гэж ангилсан.

Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогын мэдээллийг хослуулан ашиглахад онцлон тэмдэглэх нэг асуудал бол нэг сууцанд нэгээс олон өрх амьдрах боломжтой учир өрхийн тоо сууцны тооноос өндөр гарах боломжтой, мөн орон сууцны

байшингийн мэдээллийг Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар, Сууц өмчлөгчдийн холбооноос цуглуулсан учир доторх сууцны тоо буюу хэдэн айлын орон сууц гэдгийг асууж тодруулахдаа үйлчилгээ эрхэлж байгаа, түрээслэх болон өөр шалтгаанаар эзгүй байгаа хаалгыг ялгаж тодорхойлоогүй. Иймд орон сууцны байшингийн доторх сууцны тоо орон сууцны байшинд амьдардаг өрхийн тоо хоорондоо зөрөх боломжтой юм.

СУУЦНЫ ТӨРӨЛ

Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг нийт 10194 сууц, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулбал 11221 сууц тоологдсон. Харин хүн байнга амьдардаггүй илүү гэр, зуслангийн байшин зэрэг 3404 сууц тоологджээ.

Тооллогоор хүн байнга амьдардаг сууцны дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан. Харин хүн байнга амьдардаггүй байшин, илүү гэр, зуслангийн байшин зэрэг сууцны дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулаагүй болно. Тиймээс энэ бүлэгт хүн байнга амьдардаг 10194 гэр, байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 11221 сууцны дэлгэрэнгүй үр дүнг танилцуулах болно.

ЗУРАГ 12.1. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн байнга амьдардаг сууцыг төрлөөр авч үзвэл 80.1 хувь нь гэр сууц, 17 хувь нь сууцны тусдаа байшин, 1.7 хувь нь бие даасан тохилог сууц, 0.4 хувь нь нийтийн байр байгаа бол 0.8 хувь нь нийтийн зориулалттай орон сууцны байшин байна. Нийтийн зориулалттай орон сууцны байшинд 1112 сууц тоологдсон байна. Аймгийн хэмжээнд тоологдсон хүн байнга амьдардаг сууцны 30.4 хувь нь аймгийн төв Сайнцагаан суманд, 12.3 хувь нь Эрдэнэдалай суманд, 6.6 хувь нь Адаацаг суманд тус тус тоологдсон байна.

ЗУРАГ 11.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, 2020 ОН



Хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр нийт өрхийн 78 хувь нь монголын ард түмний уламжлалт сууц гэрт, 21.3 хувь нь байшинд, 0.7 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 4.4 пунктээр буурсан бол байшинд амьдардаг өрхийнх 4.1 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.1. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	14212	100.0	3726	100.0	10486	100.0
Гэр	11091	78.0	2046	54.9	9045	86.3
Байшин	3026	21.3	1650	44.3	1376	13.1
Бусад	95	0.7	30	0.8	65	0.6

Хот, хөдөөд амьдарч байгаа өрхийн сууцны төрөл ялгаатай байна. Хотын байшинд амьдардаг өрхийн тоо тооллого хооронд 16.3 пунктээр өссөн, харин гэрт амьдардаг өрхийн эзлэх хувь 16.2 пунктээр буурчээ. Хөдөөгийн өрхийн 86.3 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 2.1 пунктээр буурчээ. Ийнхүү хот, хөдөөд байшинд амьдардаг өрхийн тоо өсч байгаа нь тохилог сууцанд суугчдын тоо нэмэгдэхийн зэрэгцээгээр иргэд өөрсдөө байшин барьж суух нь олширч байгаатай холбоотой.

Байшинг төрлөөр авч үзэхэд 2010 оны тооллогынхоос бага зэрэг ялгаатай ч харьцуулалт хийх бололцоотой юм. Орон сууцны байшинд суудаг өрхийн тоо нийт өрхийн 6.4 хувийг эзэлж, 2010 оныхоос 2.2 пунктээр өссөн байна. Бие даасан тохилог сууцанд амьдардаг өрхийн тоо нийт өрхийн 1.3 хувийг эзэлж, 2010 оныхоос 0.9

пунктээр өсчээ. Харин сууцны тусдаа байшинд суудаг өрхийн хувийн жин 12.3 хувьд хүрч 2010 оныхоос 1.6 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 12.2. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	2010		2020	
	Өрх	Дүнд эзлэх хувь	Өрх	Дүнд эзлэх хувь
БҮГД	10895	100.0	14212	100.0
Гэр	8974	82.4	11091	78.0
Бусад сууц	49	0.4	95	0.7
Байшин	1872	17.2	3026	21.3
Орон сууцны байшин	460	4.2	906	6.4
Бие даасан тохилог сууц	48	0.4	187	1.3
Сууцны тусдаа байшин	1160	10.7	1755	12.3
Нийтийн байр	204	1.9	178	1.3

Гэрт амьдардаг өрхийг байршлаар нь харахад аймгийн төвд оршин суудаг өрхийн 71.1 хувь, сумын төвд оршин суудаг өрхийн 77.4 хувь, хөдөөгийн өрхийн 98.5 хувь нь гэрт амьдарч байна.

ХҮСНЭГТ 12.3. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд	Байршил		
		Хөдөө	Сумын төв	Аймгийн төв
БҮГД	14212	8954	1532	3726
Гэр	11091	8016	1029	2046
Байшин	3026	900	476	1650
Бусад	95	38	27	30

ОРОН СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР

Өрхийн амьдарч байгаа сууцны өмчийн хэлбэрийг иргэний, хувийн аж ахуйн нэгж байгууллагын, төрийн өмчийн гэж 3 ангилж үзсэн.

ХҮСНЭГТ 12.4. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Сууцны төрөл	Бүгд		Өмчийн хэлбэр		
	Өрх	дүнд эзлэх хувь	Иргэний	Хувийн ААНБ-ын	Төрийн өмчийн
2010					
БҮГД	10895	100.0	96.7	1.0	2.3
Гэр	8974	100.0	99.5	0.1	0.4
Байшин	1872	100.0	84.7	4.3	11.0

Бусад	49	100.0	44.9	22.4	32.7
2020					
БҮГД	14212	100.0	98.6	0.3	1.1
Гэр	11091	100.0	99.8	0.1	0.1
Байшин	3026	100.0	94.6	0.9	4.5
Бусад	95	100.0	84.2	4.2	11.6

Аймгийн нийт өрхийн 98.6 хувь нь иргэний, 0.3 хувь нь аж ахуй нэгж байгууллагын, 1.1 хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байна. 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад өөрийн өмчлөлийн сууцанд амьдарч байгаа өрхийн эзлэх хувь 1.9 пунктээр өссөн байна. Гэрт амьдарч амьдарч байгаа бараг бүх өрх буюу 99.5 хувь нь хувийн өмчийн гэрт амьдарч байна. Харин байшинд амьдардаг өрхийн 4.5 хувь нь төрийн өмчийн сууцанд амьдарч байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 6.5 пунктээр буурсан нь жил ирэх тусам төрийн өмчийн сууцнууд багасаж байгааг харуулж байна.

ХҮСНЭГТ 12.5. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ӨМЧИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Өмчлөлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
БҮГД	14212	100.0	3726	100.0	10486	100.0
Төрийн өмчийн	152	1.1	9	0.2	143	1.4
Хувийн ААНБ-ын	46	0.3	4	0.1	42	0.4
Иргэний	14014	98.6	3713	99.7	10301	98.2

Өрхийн сууцны өмчийн хэлбэрийг хот, хөдөөгөөр авч үзэхэд төрийн өмчийн сууцанд амьдарч байгаа өрх хөдөөд (1.4 хувь), хотоос (1.2 хувь) илүү байгаа бол хувийн өмчийн сууцанд амьдарч байгаа өрх хөдөөд (98.2 хувь), хотынхоос (99.7 хувь) бага байна.

ХҮСНЭГТ 12.6. ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Эзэмшлийн хэлбэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
2010						
БҮГД	10895	100.0	3816	100.0	7079	100.0
Өөрийн эзэмшлийн	10400	95.5	3617	94.8	6783	95.8
Бусдын сууцанд түрээстэй суудаг	251	2.3	94	2.5	157	2.2
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	191	1.8	74	1.9	117	1.7
Бусад	53	0.5	31	0.8	22	0.3
2020						
БҮГД	14212	100.0	3726	100.0	10486	100.0

Өөрийн эзэмшлийн	13515	95.1	3531	94.8	9987	95.2
Бусдын сууцанд түрээстэй суудаг	276	1.9	71	1.9	205	2.0
Бусдын сууцанд түрээсгүй суудаг	400	2.8	115	3.1	285	2.7
Бусад	21	0.1	9	0.2	12	0.1

Өрх, хүн амын хэдэн хувь нь өөрийн гэсэн орон сууцтай вэ гэдгийг тодорхойлох үзүүлэлт бол өрхийн сууцны эзэмшил юм. Сууцны эзэмшлийг хэлбэрээр нь үзэхэд аймгийн хэмжээнд нийт өрхийн 4.8 хувь буюу 697 өрх өөрийн гэсэн сууцгүй бусдын сууцанд амьдарч байна. Эдгээрийн 195 өрх нь хотынх, 502 өрх нь хөдөөгийнх байна.

ӨРХИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖ

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор нийт өрхийн 99.3 хувь, гэрт амьдардаг өрхийн 99.1 хувь, байшинд амьдардаг өрх 100 хувь цахилгааны эх үүсвэрт холбогдсон байна.

ХҮСНЭГТ 12.7. ӨРХИЙН ТОО, ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2020 ОН

Цахилгааны эх үүсвэр	Бүгд		Хот		Хөдөө	
	Өрх*	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
БҮГД	14117	100.0	3696	100.0	10421	100.0
Төвлөрсөн систем	7732	54.8	3685	99.7	4047	38.8
Дизель станц	-	-	-	-	-	-
Сэргээдэх эрчим хүчний төхөөрөмж	6142	43.5	5	0.1	6137	58.9
Бага оврын цахилгаан үүсгүүр	139	1.0	3	0.1	136	1.3
Цахилгааны эх үүсвэргүй	104	0.7	3	0.1	101	1.0
ГЭР	11091	100.0	2046	100.0	9045	100.0
Төвлөрсөн систем	4842	43.7	2037	99.6	2805	31.0
Дизель станц	-	-	-	-	-	-
Сэргээдэх эрчим хүчний төхөөрөмж	6011	54.2	5	0.2	6006	66.0
Бага оврын цахилгаан үүсгүүр	134	1.2	1	-	133	1.0
Цахилгааны эх үүсвэргүй	104	0.9	3	0.1	101	1.0
БАЙШИН	3026	100.0	1650	100.0	1376	100.0
Төвлөрсөн систем	2890	95.5	1648	99.9	1242	90.3
Дизель станц	-	-	-	-	-	-
Сэргээдэх эрчим хүчний төхөөрөмж	131	4.3	-	-	131	9.5
Бага оврын цахилгаан үүсгүүр	5	0.2	2	0.1	3	0.2
Цахилгааны эх үүсвэргүй	-	-	-	-	-	-

*Зориулалтын бус сууцанд амьдарч байгаа өрхийн тоо ороогүй

Аймгийн хэмжээнд 104 өрх цахилгаангүй байна. Энэ нь өмнөх тооллогын үеийнхээс 5.4 дахин буурсан үзүүлэлт юм. Цахилгаан эрчим хүчээр хангагдаагүй өрхийн эзлэх хувь 0.7 байгаа нь улсын дунджаас 0.2 пунктээр илүү байна. Цахилгаангүй өрх 100 хувь нь гэрт амьдардаг бөгөөд тэдгээрийн 97.1 хувь нь хөдөө


оршин суудаг ажээ. Сэргээгдэх эрчим хүч ашигладаг өрхийн 99.9 хувь хөдөө орон нутагт байна.

ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Аймгийн хэмжээнд 8166 гэр сууцанд 11091 өрх тоологдсон нь нийт өрхийн 78 хувийг эзэлж, 2010 онтой харьцуулахад 4.4 пунктээр буурчээ.

Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдардаг гэр сууцны дээвэр, туурга, шалны материалыг тодруулан асуусан. Хүн байнга амьдардаг гэр сууцны 96.8 хувь нь өвлийн улиралд давхар, 3.2 хувь нь дан дээвэр туургатай байдаг гэж хариулжээ. Аймгийн хэмжээнд нийт гэрийн 65.7 хувь нь шалгүй, 26.7 хувь нь модон шалтай, 7.4 хувь нь цементэн шалтай, 0.2 хувь нь бусад төрлийн шалтай байна.

ЗУРАГ 12.3. ГЭРИЙН ДЭЭВЭР, ТУУРГА, ШАЛНЫ ҮНДСЭН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



ХҮСНЭГТ 12.8. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, ГЭРИЙН ХАНЫН ТОО, ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Ханын тоо							
			5-аас цөөн		5		6		6-аас дээш	
	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
2010										
БҮГД	8974	100.0	3717	43.7	4967	55.4	73	0.8	12	0.1
1-2	2662	100.0	1498	56.3	1145	43.0	15	0.6	4	0.1

3-4	4180	100.0	1656	39.6	2481	59.4	37	0.9	6	0.1
5-6	1878	100.0	680	36.2	1180	62.8	16	0.9	2	0.1
7+	254	100.0	88	34.6	161	63.4	5	2.0	-	-

2020

БҮГД	11091	100.0	3717	33.5	7332	66.1	37	0.3	5	0.0
1-2	4335	100.0	1721	39.7	2602	60.0	10	0.2	2	0.0
3-4	3927	100.0	1228	31.3	2681	68.3	16	0.4	2	0.1
5-6	2425	100.0	661	27.3	1752	72.2	11	0.5	1	0.0
7+	404	100.0	107	26.5	297	73.5	-	-	-	-

Гэрт амьдардаг өрхийн 66.1 хувь нь 5 ханатай гэрт амьдарч байгаа нь улсын дунджаас 2.6 пунктээр бага байна. Нийт гэрт амьдардаг өрхийн 33.5 хувь нь 5-аас бага ханатай гэрт амьдарч байгаагийн 46.3 хувь нь 1-2 ам бүлтэй байна.

Гэрт амьдардаг өрхийн ахуй нөхцөлийн талаар бие засах газар, хатуу хог, хаягдал болон бохир ус зайлуулах хэлбэр гэсэн үзүүлэлтийг тухайн өрхөөс асуусан бөгөөд үр дүнг нь нэгтгэвэл дараах байдалтай байна.

ХҮСНЭГТ 12.9. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ахуйн нөхцөл	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ				100.0	100.0	100.0
Сайжруулсан	-	-	-	1.9	6.9	0.8
Энгийн	-	-	-	74.5	92.5	70.5
Био жорлон	-	-	-	0.1	0.3	0.1
Задгай	38.3	18.1	47.1	23.4	0.3	28.6
БИЕ ЗАСАХ ГАЗАР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бусадтай хамтран ашигладаг	61.7	68.6	57.0	35.7	46.0	31.3
Бусадтай хамтран ашигладаггүй	38.3	31.4	43.0	64.3	54.0	68.7
ХАТУУ ХАГ ХАЯГДЛАА ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Үйлчилгээний байгууллагаар	36.2	75.0	28.4	28.3	84.0	15.8
Өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт	20.7	5.0	21.5	21.2	15.7	22.5
Шатаадаг	-	-	-	5.2	0.1	6.4
Булдаг	-	-	-	0.6	-	0.7
Тогтсон газар байхгүй	43.1	20	50.1	44.7	0.1	54.7
БОХИР УС ЗАЙЛУУЛАХ ХЭЛБЭР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Цооногт асгадаг	55.4	79.3	45.0	51.0	97.9	40.3
Задгай асгадаг	44.6	20.7	55.0	49.0	2.1	59.7


Бие засах тодорхой цэггүй өрх нийт өрхийн 23.4 хувийг эзэлж байгаа бол хотод 0.3 хувь, хөдөөд 28.6 хувь байна. Энэ нь өмнөх тооллогын үеийнхээс 14.9 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Хатуу хог, хаягдлаа хаях тогтсон цэггүй өрх нийт өрхийн 44.7 хувь, бохир усаа задгай асгадаг өрх 49.0 хувь байгаа нь оршин суугчдын орчны эрүүл ахуйн нөхцөлд сөргөөр нөлөөлөх талтай юм. Дээрх үзүүлэлтүүд 2010 оны тооллогын үеийнхээс харгалзан 1.6, 4.4 пунктээр нэмэгджээ.

Ундны усны баталгаат эх үүсвэрт төвлөрсөн систем, төвлөрсөн системд холбогдсон болон холбогдоогүй ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг, шанд, цэвэршүүлэн савласан усыг оруулдаг бол хамгаалагдаагүй худаг, булаг, шанд, зөөврийн ус, гол, мөрөн, нуур зэрэг гадаргуугийн усыг сайжруулсан ундны усны эх үүсвэрт оруулдаггүй.

Гэрт амьдардаг өрхийн 33 хувь нь баталгаатай ундны эх үүсвэрээс ундны усаа авч байна. Харин 67 хувь нь баталгаагүй ундны ус зөөврийн ус хэрэглэж байна. Энэ нь гэрт амьдардаг өрхийн олонх нь хөдөө амьдардагтай холбоотой. Дээрх үзүүлэлтийг 2010 оны тооллоготой харьцуулбал баталгаагүй ундны ус хэрэглэж байгаа өрх 16.9 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 12.4. ГЭРТ АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖ, ХУВИАР, 2020 ОН



БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ СУУЦНЫ БАГТААМЖ


Байшин, орон сууцны болон Хүн ам, орон сууцны тооллогод байшинд дараах сууцуудыг хамруулсан. Үүнд:

1. Орон сууцны байшин
 - 1.1. Орон сууцны байшингийн доторх сууц
2. Сууцны тусдаа байшин
3. Бие даасан тохилог сууц
4. Нийтийн байр

Аймгийн хэмжээнд 2028 байшин, орон сууцны доторх сууцыг оруулаад 3055 байшин сууц тоологдсон байна.

Эдгээр байшингийн хийц, ашиглалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулсан ба үр дүнг нэгтгэвэл дараах байдалтай байна.

ЗУРАГ 12.5. БАЙШИН, АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОН, ХУВИАР, 2019 ОН




Нийт тоологдсон байшингийн 50.0 хувь нь 2009-2019 онд, 20.8 хувь нь 2000-2009 онд, 13.4 хувь нь 1990-1999 онд, 11.0 хувь нь 1980-1989 онд, 2.2 хувь нь 1970-1979 онд, 1.2 хувь нь 1960-1969 онд, 0.2 хувь нь 1950-1959 онд тус тус ашиглалтанд орсон байна. Байшинг төрлөөр нь ангилан харвал нийтийн зориулалттай орон сууцны байшингийн 61.2 хувь нь 2009-2019 онд ашиглалтанд орсон бол, Сууцны тусдаа байшингийн дийлэнх нь буюу 48.7 хувь нь 2009-2019 онд ашиглалтанд оржээ. Бие даасан тохилог сууцны дийлэнх буюу 93.5 хувь нь сүүлийн 20 жил буюу 2000-2019 онд ашиглалтад орсон бол нийтийн байрны хувьд дийлэнх 69.2 хувь нь их бүтээн байгуулалтын он жилүүд болох 1970-1989 онуудад ашиглалтад оржээ.

ХҮСНЭГТ 12.10. БАЙШИНГИЙН ТОО, ХАНЫН ҮНДСЭН МАТЕРИАЛ, ХАНЫН ӨНГӨЛГӨӨНИЙ МАТЕРИАЛ СУУЦНЫ ТӨРЛӨӨР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

	Бүгд		НЗОСБ		Сууцны тусдаа байшин		Бие даасан тохилог сууц		Нийтийн байр	
	Сууц	дүнд эзлэх хувь	Сууц	дүнд эзлэх хувь	Сууц	дүнд эзлэх хувь	Сууц	дүнд эзлэх хувь	Сууц	дүнд эзлэх хувь
Ханын үндсэн материал	2028	100.0	85	100	1734	100	170	100	39	100
Цутгамал төмөр бетон	12	0.6	5	5.9	4	0.2	3	1.8	-	-
Угсармал төмөр бетон	7	0.3	1	1.2	4	0.2	2	1.2	-	-
Блок	546	26.9	10	11.8	506	29.2	13	7.6	17	43.6
Тоосго	502	24.8	52	61.2	380	21.9	65	38.2	5	12.8
Мод	755	37.2	-	-	717	41.3	26	15.3	12	30.8
Сэндвич хавтан	13	0.6	-	-	11	0.6	1	0.6	1	2.6
Холимог	147	7.2	14	16.5	74	4.3	55	32.4	4	10.3
Бусад	46	2.3	3	3.5	38	2.2	5	2.9	-	-
Ханын өнгөлгөө, гадна фасадны материал	2028	100	85	100.0	1734	100.0	170	100.0	39	100.0
Цементэн шавардлага	628	31.0	41	48.2	528	30.4	32	18.8	27	69.2
Мод	99	4.9	-	-	91	5.2	8	4.7	-	-
Металл хавтан	48	2.4	1	1.2	38	2.2	8	4.7	1	2.6
Хуванцар хавтан	26	1.3	2	2.4	23	1.3	1	0.6	-	-
Чулуун хавтан	5	0.2	-	-	4	0.2	1	0.6	-	-
Тоосго	1020	50.3	37	43.5	875	50.5	100	58.8	8	20.5
Шар шавар	46	2.3	1	1.2	44	2.5	1	0.6	-	-
Плита	6	0.3	-	-	5	0.3	1	0.6	-	-
Бусад	76	3.7	3	3.5	52	3.0	18	10.6	3	7.7
Байхгүй	74	3.6	-	0.0	74	4.3	-	-	-	-

Байшин сууцны ханын үндсэн материалын дийлэнхийг буюу 88.9 хувийг блок, тоосго, мод эзэлж байгаа бол ханын өнгөлгөө, гадна фасадны материалын 81.3 хувийг цементэн шавардлага, тоосго эзэлж байна. Сууцны төрлөөр дэлгэрүүлж харвал нийтийн зориулалттай орон сууцны байшингийн ханын үндсэн материалны 61.2 хувь нь тоосго, 11.8 хувь нь блок, 16.5 хувь нь холимог, харин ханын өнгөлгөөний 48.2 хувь нь цементэн шавардлага, 43.5 хувь нь тоосго тус тус эзэлж байна. Сууцны тусдаа байшингийн ханын үндсэн материалын 92.4 хувь нь блок, тоосго, мод эзэлж байгаа бол өнгөлгөөний материалын 50.5 хувь нь тоосго, 30.4 хувь нь цементэн шавардлага байна.

ЗУРАГ 12.6. БАЙШИНГИЙН ШАЛНЫ ҮНДСЭН БОЛОН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН



Байшин сууцны 62.5 хувь нь бетон цементен шалтай, 36 хувь нь модон шалтай, 1.5 хувь нь бусад төрлийн материалан шалтай байна. Байшин сууцны шалны хучилтад 42.5 хувь нь хулдаас, 38.7 хувь нь шахмал паркет, 8.6 хувь нь модон паркет, 6.3 хувь нь бусад төрлийн материал, 2.6 хувь нь модон хучилттай байгаа бол 0.4 хувь нь хучилтын материалгүй байна.

ХҮСНЭГТ 12.11. БАЙШИНГИЙН ДЭЭВРИЙН ХУЧИЛТЫН МАТЕРИАЛ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2019 ОН

Дээврийн материал	Бүгд	Сууцны тусдаа байшин, бие даасан тохилог сууц, нийтийн байр	Орон сууцны байшин
БҮГД	100.0	100.0	100.0
Төмөр	72.0	74.3	24.2
Шавар	1.8	1.5	6.3
Шифр	8.0	8.4	1.1
Зөөлөн дээвэр	0.9	0.8	3.2
Хар цаас	10.9	9.0	51.6
Бусад	6.4	6.0	13.7

Орон сууцны байшингаас бусад төрлийн байшингийн дээврийн хучилтад төмөр (72 хувь) материалыг түлхүү ашигласан бол нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дээврийн хучилтад хар цаас (51.6 хувь)-ыг түлхүү хэрэглэжээ.

БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Аймгийн хэмжээнд 2028 байшин, орон сууцны байшингийн доторх сууцыг оруулаад 3055 байшин сууцанд 3026 өрх тоологдсон байна. Байшинд амьдардаг өрхийн тоо өмнөх тооллогын үеийнхээс 4.1 пунктээр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 12.12. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд		Сууцны талбай (квадрат метр)					
	Өрх	дүнд эзлэх хувь	20 хүртэл		21-40		40-өөс дээш	
			Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь	Өрх	дүнд эзлэх хувь
2010								
БҮГД	1835	100.0	250	13.6	691	37.7	894	48.7
1-2	528	100.0	101	19.1	221	41.9	206	39.0
3-4	926	100.0	124	13.4	333	36.0	469	50.6
5-6	319	100.0	22	6.9	117	36.7	180	56.4
7+	62	100.0	3	4.8	20	32.3	39	62.9
2020								
БҮГД	3025	100.0	280	9.3	676	22.3	2069	68.4
1-2	1122	100.0	138	12.3	278	24.8	706	62.9
3-4	1198	100.0	94	7.8	277	23.1	827	69.0
5-6	618	100.0	45	7.3	106	17.2	467	75.6
7+	87	100.0	3	3.4	15	17.2	69	79.3

Байшинд амьдардаг өрхийн 22.3 хувь нь 21-40 метр квадрат талбайтай сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 15.4 пунктээр буурсан ба улсын дунджаас 2.1 пунктээр бага байна. Гэтэл 40-өөс дээш метр квадрат талбайтай байшинд суудаг өрхийн хувь 68.4 хувь болж, өмнөх тооллогынхоос 19.7 пунктээр өссөн байгаа нь ерөнхийдөө орон сууцны багтаамж сайжирсан гэж үзэж болно. 7-оос дээш ам бүлтэй 79.1 хувь нь 40-өөс дээш метр квадрат талбайтай байранд амьдарч байгаа нь өмнөх тооллогоос 16.2 пунктээр өссөн байна.

ХҮСНЭГТ 12.13. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО, ӨРӨӨНИЙ ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

Ам бүлийн тоо	Бүгд	Өрөөний тоо					
		1	2	3	4	5-7	8+
2010							
БҮГД	100.0	30.6	46.1	17.3	4.7	1.2	1.2
1-2	100.0	37.1	46.2	13.1	3.0	0.6	0.6
3-4	100.0	29.8	45.7	18.5	4.6	1.4	1.4

5-6	100.0	24.8	45.4	20.7	7.5	1.3	1.3
7+	100.0	17.7	56.5	17.8	4.8	3.2	3.2
2020							
БҮГД	100.0	24.3	50.2	20	4.3	1.2	-
1-2	100.0	34.2	49.1	14.9	0.9	0.9	-
3-4	100.0	24.1	54.0	16.6	4.8	0.5	-
5-6	100.0	15.2	43.8	31.4	6.7	2.9	-
7+	100.0	14.3	57.1	21.4	7.2	-	-

Тооллогоор байшинд амьдардаг өрхийн 74.5 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байна. Энэ нь улсын дунджаас 2.4 пунктээр илүү байна. Өрхийн ам бүлийн дундаж үзүүлэлт болох 3-4 ам бүлтэй өрхийн 78.1 хувь 1-2 өрөөтэй сууцанд амьдарч байгааг өмнөх тооллогын үеийнхтэй харьцуулахад 2.6 пунктээр, 7, түүнээс дээш ам бүлтэй өрхийн 57.1 хувь 2 өрөөтэй сууцанд амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 0.6 пунктээр тус тус өссөн байна.

ДЭД БҮТЦИЙН ХАНГАМЖ

Байшинд амьдардаг өрхийн 40.6 хувь төвлөрсөн халаалтын системд холбогдсон байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 7.6 пунктээр өсчээ. Хотын төвлөрсөн халаалттай байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь өмнөх тооллогоос 8.6 пунктээр нэмэгдэж 62.5 хувь байна. Харин ердийн галлагаатай сууцанд амьдардаг иргэдийн хувь хөдөөд 71.6 байгаа нь 2010 оны тооллогоос 13.2 пунктээр буурсан байна.

ХҮСНЭГТ 12.14. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН ТОО, ХАЛААЛТЫН ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨ, ХУВИАР, 2010, 2020 ОН

Халаалтын төрөл	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн	33.0	53.9	4.5	40.6	62.5	14.2
Нам даралтын зуух	8.2	6.9	9.9	10.0	8.5	11.8
Цахилгаан халаагуур	0.5	0.4	0.8	1.9	1.4	2.4
Ердийн галлагаа	58.3	38.9	84.8	47.6	27.6	71.6

Халуун, хүйтэн устай сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь 3.3 байгаа нь өмнөх тооллогын дүнтэй харьцуулахад 0.2 пунктээр буурлаа. Энэ үзүүлэлт хотод 3.3 хувь, хөдөөд 3.3 хувь буюу ижил түвшинд байгаа нь сүүлийн жилүүдэд хот хөдөөгийн ялгаа арилж буйг харуулж байна. Байшинд амьдардаг өрхийн 60.3 хувь буюу 1825 өрх зөөврийн ус хэрэглэж байгаагийн дотор 605 нь хотын өрх байна. Байшинд амьдардаг, зөөврийн ус хэрэглэдэг өрхийн эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 8.7 пунктээр буурчээ.

ХҮСНЭГТ 12.15. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН УСАН ХАНГАМЖИЙН ТӨРӨЛ, 2010, 2020 ОН

Усан хангамж	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн усан хангамж	30.6	52.6	0.3	38.9	62.7	10.5
Халуун, хүйтэн устай	3.5	5.6	0.3	3.3	3.3	3.3
Зөвхөн хүйтэн устай	27.6	46.8	-	35.7	59.4	7.2
Төвлөрсөн бус усан хангамж	69.4	47.4	99.4	61.1	37.3	89.5
Бие даасан систем	0.4	0.2	0.7	0.8	0.7	0.9
Халуун, хүйтэн устай	0.1	0.1	0.2	0.3	0.1	0.6
Зөвхөн хүйтэн устай	0.3	0.1	0.5	0.4	0.5	0.3
Зөөврийн	69.0	47.2	99	60.3	36.7	88.7

Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтийн нэг нь онгоц, шүршүүр юм. Энэхүү үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ямар байгааг тодруулах, энэ төрлийн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь эх үүсвэр болно.

ХҮСНЭГТ 12.16. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН АХУЙН НӨХЦӨЛИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН

	2010			2020		
	Бүгд	Хот	Хөдөө	Бүгд	Хот	Хөдөө
БИЕ ЗАСАХ ГАЗРЫН ТӨРӨЛ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Төвлөрсөн шугам руу урсдаг	-	-	-	35.9	59.5	7.6
Цооногт урсгадаг	-	-	-	2.5	2.8	2.0
Нүхэн жорлонд урсгадаг	-	-	-	0.6	0.1	1.2
Сайжруулсан	-	-	-	2.3	2.6	2.0
Энгийн нүхэн жорлон	-	-	-	57.3	34.9	84.2
Био жорлон	-	-	-	-	-	0.1
Тогтсон газар байхгүй	-	-	-	1.4	0.1	3.0
БИЕ ЗАСАХ ГАЗАР	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бусадтай хамтран ашигладаг	35.1	32.9	37.4	23.6	13.1	32.6
Бусадтай хамтран ашигладаггүй	54.8	50.4	59.3	76.4	86.9	67.4
Тогтсон газар байхгүй	1.7	0.2	3.2	-	-	-
ОНГОЦ, ШҮРШҮҮРИЙН ӨРӨӨ	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Онгоц, шүршүүртэй	23.1	37.7	3.0	26.0	45.0	6.7
Байнгын суурилуулсан	22	14.6	1.2	23.8	42.7	4.8
Угсардаг / зөөврийн/	1.1	0.8	0.3	2.2	2.3	1.9
Нийтээрээ ашигладаг	0.6	0.9	0.3	6.4	6.0	8.0
Өрөөгүй	90.9	83.7	98.2	74.0	55.0	93.3

Байшинд амьдардаг өрхийн бие засах газрын төрлийг авч үзвэл нийт байшинд амьдардаг өрхийн 35.9 хувь нь төвлөрсөн шугам руу урсдаг, 57.3 хувь нь энгийн нүхэн жорлон хэрэглэж байна. Хот хөдөөгөөр авч үзвэл хотын байшинд амьдардаг өрхийн 59.5 хувь нь төвлөрсөн шугам руу урсдаг бол хөдөөгийн байшинд амьдардаг өрхийн 84.2 хувь нь энгийн нүхэн жорлонтой байна.


Байшинд амьдардаг өрхийн ахуйн нөхцөлийн үндсэн үзүүлэлтүүдийн нэг нь онгоц, шүршүүр юм. Энэхүү үзүүлэлт нь хүн амын эрүүл ахуйн нөхцөл, ариун цэврийн байгууламжийн хүртээмж ямар байгааг тодруулах, энэ төрлийн бодлого, хөтөлбөр боловсруулах суурь эх үүсвэр болно

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор онгоц, шүршүүртэй эсэх асуултыг онгоц, шүршүүртэй, нийтээрээ ашигладаг, онгоц, шүршүүргүй гэж 3 ангилж байсан бол 2020 оны тооллогоор онгоц, шүршүүртэй, онгоц, шүршүүргүй гэж 2 ангилж, онгоц, шүршүүртэй бол бусадтай хамтран ашигладаг эсэхийг тодруулж асуусан болно.

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор өрхийн бие засах газрын төрлийг асуугаагүй тул 2020 оны тооллоготой харьцуулах боломжгүй юм.


Байшинд амьдардаг нийт өрхийн 26 хувь нь онгоц шүршүүртэй байгааг өмнөх тооллоготой харьцуулахад 2.9 пунктээр өсчээ. Энэ үзүүлэлт хотод 7.3 пункт, хөдөөд 3.7 пунктээр тус тус өсчээ. Байнгын суурилуулсан онгоц, шүршүүртэй байшинд амьдардаг өрх нийт байшинд амьдардаг өрхийн 23.8 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлт хотод 42.7 хувь байхад, хөдөөд 4.8 хувь байгаа нь хангалтгүй байна. Харин онгоц, шүршүүргүй өрхийн хувь аймгийн хэмжээнд 74.0 хувь байхад хөдөөд 93.3 хувь байна.

ЗУРАГ 12.7. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН, ХАТУУ ХОГ, ХАЯГДАЛ ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН



Байшинд амьдардаг өрхийн 63.5 хувь нь үйлчилгээний байгууллагаар хог хаягдлаа зайлуулж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс 8.6 пунктээр буурсан байна. 2010 онд байшинд суудаг өрхийн 2.1 хувь нь хатуу хог хаягдлаа зайлуулах тодорхой цэггүй байсан бол 2020 онд 3.7 болж өсчээ.

ЗУРАГ 12.8. БАЙШИНД АМЬДАРДАГ ӨРХИЙН БОХИР УС ЗАЙЛУУЛАЛТЫН ХЭЛБЭР, ХУВИАР, 2020 ОН



Байшинд амьдардаг өрхийн 36.6 хувь нь төвлөрсөн системээр, 2.7 хувь нь бие даасан системээр шингэн хог хаягдлаа зайлуулж, 56.7 хувь нь цооногт, үлдсэн 4 хувь нь задгай асгаж байна. Цооногт асгаж байгаа хувь өндөр байгаа нь сууцны тусдаа байшинд амьдардаг өрх байшинд амьдардаг өрхийн дийлэнхийг бүрдүүлж байгаатай холбоотой.